

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
2024 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	1
1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	1
1.2. ХӨРВӨХ ЧАДВАР	2
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД.....	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ	3
2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ	3
2.1.1. Хувьцааны арилжаа	3
2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа	5
2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа	5
2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	6
2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа.....	6
2.1.6. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа	7
2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ	8
2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц	8
2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД	9
3.1. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан	11
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ.....	12
4.1. Хууль, эрх зүйн орчны шинэчлэл.....	12
4.2. Хамтын ажиллагаа	12
4.3. Гадаад хамтын ажиллагаа	13
4.4. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдлээ	14
4.5. Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай	14


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 11.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80.7 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 17.1 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 175 компани болон 2 хамтын хөрөнгө оруулалтын сангаас дараах 30 компанийн зах зээлийн үнэлгээ 11.13 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 94.35 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани


№	Компанийн нэр	Эзлэх хувь	№	Компанийн нэр	Эзлэх хувь
1	“ХААН банк” ХК	19.45%	16	“Улсын Их Дэлгүүр” ХК	0.82%
2	“Тавантолгой” ХК	12.73%	17	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	0.72%
3	“Худалдаа хөгжлийн банк” ХК	12.22%	18	“Тугал” ХК	0.62%
4	“АПУ” ХК	9.82%	19	“Монгол шуудан” ХК	0.60%
5	“Хас банк” ХК	6.33%	20	“Түмэн шувуут” ХК	0.58%
6	“Голомт банк” ХК	6.04%	21	“Монложистикс холдинг” ХК	0.57%
7	“Инвекор ББСБ” ХК	4.56%	22	“Техник импорт” ХК	0.51%
8	“Төрийн банк” ХК	3.60%	23	“Монголын хөрөнгийн бирж” ХК	0.49%
9	“МИК холдинг” ХК	2.98%	24	“Газар шим үйлдвэр” ХК	0.49%
10	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	2.69%	25	“Лэндмн ББСБ” ХК	0.45%
11	“Говь” ХК	1.78%	26	“Мандал даатгал” ХК	0.40%
12	“Монгол даатгал” ХК	1.39%	27	“Инновэйшн Инвестмент” ХК	0.36%
13	“Премиум нэксус” ХК	1.35%	28	Мандал Ирээдүйн Өсөлт	0.33%
14	“Сүү” ХК	0.97%	29	“Ард Кредит ББСБ” ХК	0.32%
15	“Богд банк” ХК	0.86%	30	“Монос Хүнс” ХК	0.32%

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.39 пунктээр өсөж, 1.01 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 76.82 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

Индекс	2023.I	2024.I	Өөрчлөлт
ТОП 20	36,723.77	44,693.58	21.70%
MSE A	15,170.17	17,799.40	17.33%
MSE B	12,478.32	12,207.55	-2.17%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 45,024.07 нэгж, доод үзүүлэлт 40,704.45 нэгж, дундаж үзүүлэлт 42,988.31 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,969.81 нэгжээр буюу 21.70 хувиар өсөж, **44,693.58** нэгж болсон байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 18,195.59 нэгж, доод үзүүлэлт 16,725.34 нэгж, дундаж үзүүлэлт 17,397.53 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,629.23 нэгжээр буюу 17.33 хувиар өсөж, **17,799.40** нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 12,731.21 нэгж, доод үзүүлэлт 11,321.67 нэгж, дундаж үзүүлэлт 12,079.01 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 270.77 нэгжээр буюу 2.17 хувиар буурч, **12,207.55** нэгж болсон байна.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 204.93 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өссөн үзүүлэлт бөгөөд нийт арилжааны 188.94 тэрбум төгрөгийн арилжаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар, 15.99 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар тус тус хийгдсэн байна.

Тайлант хугацаанд хувьцааны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 62.70 хувийг хувьцаа, 20.77 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 8.16 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 8.37 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байна.

График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)




Харин Хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд 58 удаагийн цахим арилжаа зохион байгуулагдсан ба нийт 59.5 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан бол Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 197 удаагийн арилжаа зохион байгуулагдаж нийт 2.48 их наяд төгрөгийн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна.

2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 128.48 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 145.5 хувиар буюу 2.45 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс хувьцааны анхдагч зах зээлд нийт 8.90 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 119.58 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна.



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй, арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг үнийн дүнгээр харуулбал:

Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөгөөр)

№	Компанийн нэр	Үнийн дүн	№	Компанийн нэр	Үнийн дүн
1	“Говь” ХК	67.89	16	“Мост Финтек” ХК	0.93
2	“ХААН банк” ХК	8.75	17	“Монложистикс Холдинг” ХК	0.89
3	“Богд банк” ХК	6.12	18	“Ард Кредит ББСБ” ХК	0.89
4	“Голомт банк” ХК	4.70	19	“Монгол шуудан” ХК	0.86
5	“Худалдаа хөгжлийн банк” ХК	3.23	20	“Лэндмн ББСБ” ХК	0.85
6	“Хас банк” ХК	3.11	21	“Ард Даатгал” ХК	0.60
7	“АПУ” ХК	2.84	22	“Крипто Үндэстэн” ХК	0.52
8	“Газар шим үйлдвэр” ХК	2.70	23	“Тэнгэрлиг медиа групп” ХК	0.51
9	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	2.53	24	“Төрийн Банк” ХК	0.49
10	“Инвескор ББСБ” ХК	2.50	25	“Түмэн шувуут” ХК	0.31
11	“Тавантолгой” ХК	2.17	26	“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК	0.26
12	“Монголын хөрөнгийн бирж” ХК	1.42	27	“Монос Хүнс” ХК	0.16
13	“Премиум нэксус” ХК	1.28	28	“Ариг гал” ХК	0.10
14	“Мандал даатгал” ХК	1.00	29	“Монгол базальт” ХК	0.09
15	“Эрдэнэтхүнс” ХК	0.97	30	“Атар-Өргөө” ХК	0.09
НИЙТ					118.76

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК

Тайлант хугацаанд нийт 12 хувьцаат компанийн 72.8 сая ширхэг буюу 18.39 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 15.38 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд


№	Үнэт цаасны нэр	Арилжаалагдсан ширхэг (мянган ширхэг)	Үнийн дүн (тэрбум төгрөг)
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	270.00	0.81
2	“АПУ” ХК	1,843.42	1.79
3	“Богд банк” ХК	15,971.72	1.35
4	“Премиум нэксус” ХК	6,798.08	0.82
5	“Газар шим үйлдвэр” ХК	40,000.00	2.61
6	“Голомт банк” ХК	2,334.63	3.60
7	“Инвескор ББСБ” ХК	290.28	2.00
8	“Говийн өндөр” ХК	62.67	0.01
9	“Монложистикс Холдинг” ХК	4,133.82	0.78
10	“Монгол шуудан” ХК	629.74	0.58
11	“Эрдэнэтхүнс” ХК	368.54	0.97
12	“Худалдаа хөгжлийн банк” ХК	95.56	3.07
НИЙТ		72,798.45	18.39

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 42.56 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.58 дахин өссөн үзүүлэлт юм.




2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 31 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо 1 компанийн хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, улмаар тус хувийн сан үүсгэн байгуулагдсан байна.

График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 17.16 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар өссөн өссөн дүн юм.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа


Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 17.16 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар 1.17 тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар 15.99 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 6.8 болон 93.2 хувийг бүрдүүлж байна.



2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)


Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 15.0 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 1.73 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт 16.73 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.3 дахин буюу 130.27 хувиар өссөн үзүүлэлт юм.



2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

График 9. ХААБ-ээр арилжаалагдсан түүхий эдийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 58 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 364 хэлцлээр нийт 59.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 4.26 тэрбум төгрөгөөр буюу 6.7 хувиар буурсан үзүүлэлт юм.



ХААБ-ээр дараах төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа




Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (бүтээгдэхүүний төрлөөр)

Ямааны ноолуур	11,587,975,000	Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 70.9 хувийг ямааны завод ноос, 19.5 хувийг ямааны ноолуур, 5.7 хувийг тосны ургамал, 3.5 хувийг хонины ноос, 0.4 хувийг тэмээний ноос тус тус эзэлж байна.
Хонины ноос	2,092,900,000	
Завод ноос (ямааны)	42,176,750,000	
Тэмээний ноос	248,460,000	
Тосны ургамал (рапс)	3,402,200,000	
Нийт	59,508,285,000.00	

2.1.6. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа

2024 оны 01 дүгээр улиралд 68 удаагийн арилжаагаар 5.22 сая тонн нүүрсийг 2.39 их наяд төгрөгөөр, 59 удаагийн арилжаагаар 358.8 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 94.94 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалж, нийт 127 удаагийн арилжаагаар 5.58 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 2.48 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.


График 10. Нийт арилжаалагдсан нүүрсний хэмжээ (төрөл, ангилал, хувиар)



Тайлант хугацаанд нийт 7 төрлийн 5.22 сая тонн нүүрс арилжаалагдсанаас 1/3 коксжих нүүрс 53.55 хувийг, баяжуулсан коксжих нүүрс 14.71 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс 2.45 хувийг, баяжуулсан сул коксжих нүүрс 0.25 хувийг, дэгдэмхий бодис дундаас их, хийн нүүрс 2.45 хувийг, дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс 24.14 хувийг, эрчим хүчний нүүрс 2.45 хувийг тус тус эзэлж байна.

График 11. Нийт арилжаалагдсан төмрийн хэмжээ (төрөл, ангилал, хувиар)

Тайлант хугацаанд нийт 358.8 мянган тонн төмрийн хүдэр, баяжмал арилжаалагдсанаас 52.22 хувийг Fe-52%-ийн агууламжтай төмрийн хүдэр, 20.19 хувь Fe-58%-ийн агууламжтай төмрийн баяжмал, 27.59 хувийг Fe-65%-ийн агууламжтай төмрийн баяжмал тус тус бүрдүүлж байна.



2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Тайлант хугацаанд **187,305** шинэ данс, **55,781** холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт **2,580,599** данс, **646,243** холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 12. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хоёрдогч зах зээлийн арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 27.35 тэрбум төгрөг (16.60 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 136.37 тэрбум төгрөг (82.77 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 0.83 тэрбум төгрөг (0.51 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 0.198 тэрбум төгрөг (0.12 хувь)-ийг тус тус эзэлж нийт 164.75 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.



Дээрх арилжаанд давтагдсан тоогоор нийт 31,206 хүн, 656 аж ахуйн нэгж оролцож, 86,495 удаагийн арилжаа хийсэн байна. (Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу.)

Хүснэгт 7. Хөрөнгө оруулагчдын бүтэц (давтагдсан тоо, хувиар)

	Арилжаанд оролцогчийн тоо		Арилжаанд оролцсон тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гадаадын ААН	11	0.03%	60	0.07%
Гадаадын иргэн	225	0.71%	1,121	1.30%
Дотоодын ААН	645	2.02%	5,833	6.74%
Дотоодын иргэн	30,981	97.23%	79,473	91.89%
Нийт	31,862	100%	86,487	100%

Эх сурвалж: "МУЦКТ" ХХК

2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2024 оны 1 дүгээр улирлын хугацаанд биржийн бус зах зээлд төгрөгөөр нийт 103 компанийн нийт 2.63 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 178 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 1.95 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Мөн доллароор нийт 71.0 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 45.0 сая ам долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

Үүнээс тайлант хугацаанд 25 үнэт цаас гаргагчийн 177.98 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 29 өрийн хэрэгслийг бүртгэсэн бөгөөд нийт 207.18 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 2.6 дахин өссөн үзүүлэлт юм.

График 13. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар ангилсан тоон мэдээлэл (хувиар)





График 14. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар ангилсан тоон мэдээлэл (хувиар)

Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн татан төвлөрүүлэхээр зарласан дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал уул уурхай 2.0 хувь, банк бус 61.0 хувь, үл хөдлөх 13.0 хувь, гадаад худалдаа борлуулалт 17.0 хувь, бусад салбар 7.0 хувийг бүрдүүлж байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 290 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 8. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	3
2	Үнэт цаасны тооцооны байгууллага	2 ¹
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Үнэт цаасны төлбөрийн байгууллага	1 ²
5	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	31
6	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	6
7	Кастодиан банк	3
8	Үнэт цаасны компани	51
	Брокер	50
	Үүнээс:	
	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч	16
	Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч	17
	Дилер	34
	Андеррайтер	23 ³
	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	20
9	Хөрөнгө итгэмжлэн удирдагч	8
10	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	1
11	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани	59 ⁴
12	ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1
13	ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	9
14	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1 ⁵
15	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/	5 ⁶
16	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага	3
Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд		
17	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага	68 ⁷
	Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	52
	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага	24
18	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага	43
Нийт (ТЗ болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо)		290

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 175 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10 дугаар сарын 13-ны

¹ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “МУЦКТ” ХХК орсон болно.

² “ҮЦТХТ” ХХК нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

³ Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

⁴ Тус тоонд “МИК ОССК” ХХК-34, “ҮЦСК” ХХК-6, “Носк тав ТЗК” ХХК-5, нээлттэй хүрээнд ХБҮЦ гаргасан 13 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

⁵ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ХК орсон болно.

⁶ Нэр бүхий 5 үнэт цаасны компани тус үйл ажиллагааг давхар эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг авсан.

⁷ ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 8 компани байна.

өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

Хүснэгт 9. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нэр	Бүртгэлтэй ХК-ийн тоо	Зах зээлийн үнэлгээ 2023 он
1) “Монголын хөрөнгийн бирж” ХК -100 хувь төрийн өмчит -Төрийн өмчийн оролцоотой -Бусад	173 4 11 158	11,773,104,594,731.90 ₮ (Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.)
2) “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК	2	27,191,048,121.00 ₮
3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК	-	-

3.1. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан

2024 оны эхний улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч 17 компани байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс мөнгөн хөрөнгийн номинал дансны тайланг цахимаар хүлээн авахтай холбоотойгоор холбогдох ажлыг хийж гүйцэтгэсэнээр энэ оны эхний улирлаас компаниуд тайлангаа цахимаар ирүүлэх боломжтой болсон бөгөөд тус хугацаанд нийт 7 компани тайлангаа ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд дээрх 7 компанид бүртгэлтэй нийт 851,366 харилцагч байгаагаас 2,689 харилцагч үйлчилгээ авч, 59.75 тэрбум төгрөгийн болон 400.1 мянган ам.долларын гүйлгээ хийсэн байна.

№	Компанийн нэр	Нийт харилцагчдын тоо	Үйлчилгээ авсан харилцагчдын тоо	Нийт авсан/ зарсан гүйлгээ	Эцсийн үлдэгдэл
1	“Гүүдсек ҮЦК” ХХК (төгрөг)	739560	1025	1,335,431,243.00	160,969,628.00
	“Гүүдсек ҮЦК” ХХК (ам.доллар)	20	2	7.33	44.48
2	“Ти Ди Би секьюритис ҮЦК” ХХК	52790	1133	24,871,389,261.00	2,508,961,363.00
3	“Инвекор капитал ҮЦК” ХХК (төгрөг)	11,543.00	207	23,740,301,417.08	1,347,953,005.14
	“Инвекор капитал ҮЦК” ХХК (ам.доллар)	4	2	400,136.39	123.63
4	“Нейшнл сэкюритиес”	12877	28	32,864,206.85	25,142,183.28
5	“Новел инвестмент ҮЦК” ХХК	33872	75	5,115,216,409.00	716,555,416.00
6	“Эс Жи иневстмент энд секьюритиз ҮЦК” ХХК	6	6	627,041.56	314,958.44
7	“Стандарт инвестмент ҮЦК” ХХК	694	211	4,658,118,654.69	143,599,886.85
НИЙТ	Төгрөг	851,342	2,685	59,753,948,233.18	4,903,496,440.71
	Ам.доллар	24	4	400,143.72	168.11

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, ТОП-100 ААН-ийг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

4.1. Хууль, эрх зүйн орчны шинэчлэл

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хариуцан боловсруулахаар тусгасан. Энэ хүрээнд Сангийн сайдын 2021 оны 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс боловсруулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авсан. Улмаар Засгийн газраас дээрх хуулийн төслүүдийг 2023 оны Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганд өргөн мэдүүлж, хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал дүгнэлтийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 2 дугаар тогтоолоор байгуулсан.

Тус ажлын хэсэгт Хорооны төлөөлөл орж ажиллаж, хуулийн төслүүдэд зарчмын зөрүүтэй саналуудыг

тусган Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн хэлэлцүүлгийг хийлгүүлсэн бөгөөд хуулийн төслүүдийг соёрхон батлах ажил хүлээгдэж байна.




МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн уялдаа холбоо сайжран олон улсын жишигт нийцэх, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх, үнэт цаас гаргагч, андеррайтерийн компаниудын үүрэг оролцоо өсөх, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, төвлөрсөн болон тухайлсан бүртгэлтэй холбоотой зохицуулалт боловсронгуй болох зэрэг эерэг нөлөө хөрөнгийн зах зээлд бий болох юм.

4.2. Хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг

нэмэгдүүлэх зорилгоор “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг 2023 оны 05 дугаар сард баталсан.



Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд IPO хийх, компанийн бонд гаргахад тавигддаг нөхцөл, шаардлага, цаг хугацааг бууруулж, IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, мөн нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй байх гэх зэргээр үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах зохицуулалтуудыг холбогдох журмуудад тус тус тусгаж, нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Түүнчлэн уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлд хувьцаа, компанийн бонд гаргахад тавигдах нөхцөл, шаардлага, хугацаа, өртгийг бууруулж, хялбаршуулах зохицуулалтуудыг бүрдүүлэх, холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг хамтран боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Тухайлбал Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон мэргэжлийн оролцогч байгууллагуудтай хамтран аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд хувьцаа, бонд гаргахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх, нээлттэй компани болсноор үүсэх давуу

тал ач холбогдол болон IPO хийх процесс дараалал, компанийн засаглалын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөхөөр “Хөрөнгийн зах зээлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх нэг цэгийн үйлчилгээ”-г зохион байгуулахаар тогтсон.

Мөн Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран компаниудын удирдлагуудад зориулсан нээлттэй компани болоход тулгарч буй асуудал болон ажлын хэсгийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулах, санал солилцох уулзалтыг 4 дүгээр сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан байна.

Уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд нь IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох, компанийн бонд гаргаж санхүүжилт татах замаар хөрөнгийн зах зээлд оролцсоноор бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашиг, орлогоо өсгөх, компанийн нэр хүндээ өсгөх, урт хугацааны хямд санхүүжилтийн эх үүсвэр татах, компанийнхаа засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой юм.

4.3. Гадаад хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн бодлого зохицуулалтыг сайжруулах, хяналт, шалгалтын орчныг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд дараах хамтын ажиллагааны санамж бичгүүдийг байгууллаа:



Санхүүгийн зохицуулах хороо Бүгд Найрамдах Киргиз Улсын Үндэсний банктай хоёр улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, тэр дундаа финтек компаниудыг бодлогоор дэмжих, хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцох, газар дээрх санхүүгийн хяналт шалгалт хийхэд харилцан туслалцах, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллахаар 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хороо Унгар Улсын Төв банктай хоёр улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг бодлогоор дэмжихийн зэрэгцээ бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг хөгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлд харилцан туслалцах, хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцох, газар дээрх хяналт шалгалт хийхэд харилцан туслалцах мөн хүний нөөц, байгууллагыг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллахаар 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

4.4. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдлээ

Засгийн газрын 2024 оны 73 дугаар тогтоолоор 2023 оны 223 дугаар тогтоолд нэмэлт оруулж, "Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал"-д зэс, молибдены баяжмал болон бүтээгдэхүүнийг тус тус нэмсэн.



Үүний хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас “Зэсийн баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам”-ыг баталж, Хорооны 2024 оны 134 дүгээр тогтоолоор журам мөрдүүлэх зөвшөөрлийг авсан.

Зэсийн баяжмал уул уурхайн бүтээгдэхүүний биржээр дамжуулан арилжаалагдаж эхэлснээр арилжаа олон нийтэд нээлттэй, шударга, ил тод зохион байгуулагдаж, бүтээгдэхүүн үнийн өсөлттэй арилжаалагдах, экспортыг нэгдсэн бодлогоор хангах зэрэг олон давуу тал бий болох юм.

4.5. Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” Хорооны 2020 оны 28 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, компаниудын ногдол ашиг тараах хугацааг нарийвчлан тогтоосон. Тодруулбал, ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн компаниуд санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу дөрөвдүгээр сарын 30-ны өдрөөс өмнө ногдол ашгаа хуваарилж дуусган, тайлангаа Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж байх үүргийг нийт хувьцаат компаниуд хүлээх юм.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн тухай хуулиар компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа дөрвөн сарын дотор хуралдуулах зохицуулалттай. Гэтэл зарим хувьцаат компаниудын хувьд ногдол ашиг хуваарилах шийдвэрээ гаргасан хэдий ч тараах хугацаагаа хувьцаа эзэмшигчдэд

тодорхой зарлаагүй, эсхүл ногдол ашгаа тараахгүй удааж байгаа нь хувьцаа эзэмшигчдэд тодорхойгүй байдлыг бий болгохын зэрэгцээ зах зээлд итгэх итгэл болон идэвхийг бууруулах эрсдэлтэй тул уг асуудлыг шийдвэрлэх практик шаардлага үүссэн. Иймээс дээрх асуудлыг нарийвчлан зохицуулах ногдол ашиг

тараах хугацаа болон тайлагналын талаар уг тогтоолд тодорхой зааж өөрчлөлт оруулсан. Ингэснээр компаниуд нийт хувьцаа эзэмшигчдийн хүртэх ногдол ашгийг тогтоосон хугацаанд дансанд нь байршуулж, тэдгээрийн эрх ашгийг хамгаалахад ихээхэн ач холбогдолтой юм.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---